

## ЗАСГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ 3 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### **Санхүү, төсвийн талаар**

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нэгдүгээр төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олголоо.

Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн хоёр дахь шатны санхүүжилтийг олгох тухай, Улаанбаатар хотын гал түймэртэй тэмцэх техник, багаж хэрэгслийн чадавхийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх тухай, Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношлогооны төхөөрөмжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх тухай, Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд буцалтгүй тусламж олгох тухай Монгол Улсын Засгийн газар, Японы Улсын Засгийн газар хооронд харилцан солилцох ноот бичгүүд болон Улаанбаатар хотын гал түймэртэй тэмцэх техник, багаж хэрэгслийн чадавхийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх тухай, Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулах буцалтгүй тусламжийн хэлэлцээрт тус тус гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олгосон.

Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр эцэслэн хэлэлцэн баталж, Монгол Улсын 2012 оны төсвийн тодотголоор төсвийн орлого, зарлага, тэнцэлд дараах өөрчлөлт оруулсан байна:

1) Монгол Улсын төсвийн орлогын 2011 оны урьдчилсан гүйцэтгэл, 2012 оны эхний 1 дүгээр сарын орлогын урьдчилсан гүйцэтгэлд үндэслэн 2012 оны улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг хүлээгдэж буй гүйцэтгэлээр 161.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон байна. Улсын төсөвт 2010 оны 1 дүгээр сард импортын барааны татварын орлогоор 29.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрч байсан бол 2011 оны 1 дүгээр сард 69.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн явдал өмнөх 2010 оны мөн үеэс 2 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн 2012 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 109.1 тэрбум төгрөг импортын татварын орлогоор төвлөрсөн нь өмнөх 2011 оны мөн үеийнхээс 1.6 дахин өссөн байна.

2) Төсвийн байгууллагын албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын ба нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, зарим төрлийн тэтгэмжийг үе шаттай нэмэгдүүлэх хугацааг 2012 оны 2 дугаар сарын 1-ний болон 5 дугаар сарын 1-нээр байхаар наашлуулан тогтооход улсын төсөвт нийт 161.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсөвт 13.9 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 8.8 тэрбум төгрөгийн нэмэлт зардал шаардагдаж байна. Эдгээр нэмэгдэл зардлыг задлан үзүүлбэл: цалингийн нэмэгдэл болон нийгмийн даатгалын шимтгэлд 157.8 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрт 11.1 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр болон зарим тэтгэмжид 1.8 тэрбум төгрөг, цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу нэмэгдэх 1.4 тэрбум төгрөг, улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох татааст 7.2 тэрбум төгрөг, улсын төсвөөс

орон нутгийн төсөвт олгох татааст 5.0 тэрбум төгрөг тус тус нэмж зарцуулахаар тооцоо гарсан байна. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар Тэргүүн шадар сайдын төсвийн багцад нийт 48.5 тэрбум төгрөг, үүнээс урсгал зардалд 32.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 15.8 тэрбум тусгагдсаныг Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй уялдуулан Тэргүүн шадар сайдын төсвийн багцаас урсгал зардлын 26.3 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын 1.9 тэрбум төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад, түүнчлэн урсгал зардлын 6.4 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын 13.9 тэрбум төгрөгийг Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад тус тус шилжүүлж, улмаар Тэргүүн шадар сайдын ажлын алба татан буугдсантай холбогдуулан төсвийн зардлыг 112.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

3) Монгол Улсын 2011 оны урьдчилсан гүйцэтгэл, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдэд гарч буй өөрчлөлт, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг тусгахад нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 177.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 6,003.6 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 158.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 6,467.7 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нийт тэнцэл 464.1 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 3 хувьтай тэнцэхээр тооцоо гарсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2012 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр 674.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 41.7 тэрбум төгрөгөөр буюу 5.8 хувиар давж, улмаар 2011 оны мөн үеийнхээс 207.1 тэрбум төгрөгөөр буюу 44.3 хувиар өссөн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2012 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр 1425.5 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 806.8 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 682.1 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 491.4 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 47.9 хувийг (улсын төсвийн зарлагын 60.9 хувийг) санхүүжүүлсэн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүний хөгжил санд 2012 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) нийт орлого 55.9 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 88.9 хувиар буюу 26.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 112.5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 7.3 тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 66.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 28.2 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарлаа.

### **Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2012 оны хамтарсан 121/83 дугаар тушаалаар аймаг, нийслэлд “Эрүүл хүүхэд” аяны хүрээнд зохион байгуулах үзлэгийн хуваарийг батлав.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 95 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 34 тоот тушаалд нэмэлтээр “Чихрийн шижин хэвшинж-2, Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгийн

бүртгэл хөтлөх заавар”, “Чихрийн шижин хэвшинж-2, Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгийн бүртгэл”-ийн маягтыг тус тус баталсан.

Зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдлийн мэдээг томоохон импортлогч эм ханган нийлүүлэх байгууллагуудаас 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар авч нэгтгэн дүгнэхэд давхардсан тоогоор 310 нэрийн 3.8 тэрбум төгрөгийн ЗШЭ-ийн үлдэгдэлтэй байна.

### **Нийгмийн хамгааллын талаар**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлууллаа.

Иргэн бүрт олгох 21000 төгрөгийн хишиг, хувийг Засгийн газрын 2012 оны 96 дугаар тогтоолоор энэ оны 6 дугаар сарыг дуустал хүртээхээр болов.

Мөн 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй иргэн, холбогдох хууль, журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон 16 хүртэлх насны хүүхэд, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор тогтоогдсон 16 насанд хүрсэн иргэнд Хүний хөгжил сангаас олгох 1.0 сая төгрөгийг 2012 оны 2 дугаар улирлын сар бүрийн сүүлийн хагаст хуваан олгохоор болов.

ОУХБ-тай хамтран "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлал, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга зам" сэдэвт 2 өдрийн семинарыг 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулав.

### **Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр**

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол. 2012-2013 оны хичээлийн жилд хэрэглэх багшийн журналыг хэвлэх, түгээх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах дотоодын нээлттэй тендерийг шалгаруулж хэвлэх ажлыг эхлүүлэв.

2011-2012 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд монгол, кирилл бичгээр зэрэгцүүлсэн бичилттэй боловсролын бичиг баримт олгуулах бэлтгэл ажлыг хангаж, аймаг, дүүргийн төгсөгчдийн мэдээг нэгтгэн "Үндэсний үнэт цаас" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Кембрижийн их сургуулийн Олон Улсын шалгалтын төвийн зөвлөх үйлчилгээний багийг хүлээн авч бага, дунд боловсролын сургалтын стандарт, хөтөлбөрийн шинэчлэлийн туршилт явуулах багш нарыг сурган бэлтгэх сургагч багш нарын болон шинэ хөтөлбөр боловсруулах багийн ажилтан нар зориулсан хэд хэдэн сургалтыг уг багтай хамтран зохион байгуулж 32 сургагч багш, хөтөлбөрийн багийн 23 гишүүн, Стандартын шинэчлэлийг дэмжих нэгжийн ажилтан нарыг хамруулсны зэрэгцээ Кембрижийн их сургуулийн багийн гишүүдийг МУИС, МУБИС, Багшийн коллежийн ажил байдалтай танилцуулав.

“Албан бус боловсролын холимог бүлгийн сургалт”-ыг 2012 оны 3 дугаар сарын 5-13-ны хооронд зохион байгуулав.

Дээд болон мэргэжлийн боловсрол. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд их сургуулийн нэгдсэн хотхоны ерөнхий төлөвлөгөөний боловсруулалтын хүрээнд хийгдсэн ажлын танилцуулах уулзалтыг зохион байгуулав.

Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2012 оны 43 дугаар тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Замын цагдаагийн газрын төлөөллийг оролцуулан байгуулагдсан ажлын хэсэг Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан саналыг судлан үзээд зарим их сургууль, коллежийн болон ерөнхий боловсролын сургуулийн удирдлагатай харилцан тохиролцож, хичээлийн эхлэх хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэв.

Соёл, урлаг. 21 аймгийн төв номын санд 130, 24 театр, чуулга, 21 музей, сумын 326 Соёлын төв тус бүрт нэг, нийслэлийн 4 дүүргийн номын сан тус бүрт 4, Үндэсний номын санд 30, УБ хотын төв номын санд 20, Хүүхдийн номын ордонд 16, төвийн мэргэжлийн урлагийн 5 байгууллагад 1-3, улсын 7 музейд 8, нийт 400 сая төгрөгийн үнэ бүхий 600 компьютерийг БСШУ-ы яамны хөрөнгө оруулалтаар олгож, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

Шинжлэх ухаан, технологи. 2012 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийг ШУТ-ийн Үндэсний Зөвлөлөөр хэлэлцүүлж, БСШУ-ы сайдын тушаалаар баталгаажуулав.

Засгийн газрын 2010 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан “Судалгааны төслөөр боловсруулсан технологи, бүтээгдэхүүнийг эрэлтэд нийцүүлэн бодит хэрэглээ болгох тогтолцоог боловсронгуй болгох” арга хэмжээний хүрээнд төрийн өмчийн их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоотой гүйцэтгэх инновацийн төслүүдийг тодорхойлж БСШУ-ы сайдын 2012 оны 135 дугаар тушаалаар батлан 270 гаруй сая төгрөгөөр санхүүжүүлэх шийдвэр гаргав.

### **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр**

“Хөдөөг хоршоолох аян”, Хоршоологчдын үндэсний III чуулганыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын орчинг боловсронгуй болгох багц асуудлын талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр боллоо.

Малын эмийн салбар зөвлөл 2011 онд улсын бүртгэлд шинээр бүртгэгдсэн малын эмийн хэрэглэх зааврыг эмхэтгэн, шинэчилж 5000 ширхэгийг хэвлүүлээд байна.

Ерөнхий сайдын санаачлагаар “Монгол Улсын шилдэг малчин эмэгтэй” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” сургалтыг 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газрын хоршоо хариуцсан мэргэжилтнийг хамруулан Улаанбаатарт зохион байгуулав.

### **Зам, тээвэр, барилга хот байгуулалтын чиглэлээр**

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд баригдах 100000 айлын орон сууцны барилгын дараагийн ээлжийн жагсаалтыг Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын хуралдаанд танилцуулж, шийдвэрлэв.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Төмөр замын салбарт авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжив.

“МИАТ” төрийн өмчит хувьцаат компани болон “Корэйн Эйр” компани хооронд хамтын ажиллагааны стратегийн түншлэлийг өргөжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

2012 оны 3 дугаар сарын 05-08-ны өдрүүд БНСУ-ын Газар, тээвэр, далайн хэргийн яамны Далайн тээврийн бодлогын газрын дарга Жон Ки-Жонг тэргүүтэй төлөөлөгчид Монгол-Солонгосын Далайн тээврийн хамтарсан компани байгуулах ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангах зорилгоор Монгол Улсад ажлын айлчлал хийлээ.

### **Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын чиглэлээр**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

“Монгол Улсын хатуу ашигт малтмалын ордын нөөц, эрдсийн баялгийн ангилал”, “Монгол Улсын хатуу ашигт малтмалын ордын нөөц, эрдсийн баялгийн ангиллыг хэрэглэх заавар”-ыг баталж, холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Оюу толгой төслийг хэрэгжүүлэхэд дэд бүтцийн байгууламж байгуулахад шаардлагатай газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахаар холбогдох агентлаг, байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Нүүрсний жишиг үнийг бодитой тогтоох судалгаа хийх ажлын хүрээнд БНХАУ-ын холбогдох байгууллагуудтай уулзан туршлага судалж, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй холбогдох хүмүүс, байгууллагатай уулзалтуудыг зохион байгууллаа.

Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлийн ажлын албанд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн талаар авч хэрэгжүүлж байгаа ажлууд болон Засгийн газрын

хуралдаанаар хэлэлцсэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэргийг танилцуулах мэдээлэл хийлээ.

Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийг дэмжих төсөл”-ийн хүрээнд хийгдэх Дархан-Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн баригдах Хартөмөрлөгийн цогцолборын Техник эдийн засгийн үзүүлэлтийн (ТЭЗҮ) техникийн даалгавар боловсруулах Ажлын хэсэг Дэлхийн банкны суурин төлөөлөгчтэй уулзалт зохион байгуулж холбогдох шийдвэр гаргалаа.

### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр**

“Ойн менежментийн улсын ерөнхий төлөвлөгөө”-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан А-59/А-12 тоот тушаалаар батлав.

Хууль бус мод бэлтгэлийн талаар хяналт шалгалт хийн, үнэлгээ гаргах ажлын удирдамжийн дагуу 5 багийг Сэлэнгэ аймгийн Мандал, Түнхэл баг, Төв аймгийн Жаргалант, Батсүмбэр сумдад, болон Нийслэлийн модны захуудад томилон ажиллуулж, ажлын хэсгүүдийн тайлан зөвлөмжийг нэгтгэн боловсруулж, хууль бус мод бэлтгэлийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт, үнэлгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Хараа голын сав газрын зөвлөлөөс “Хараа голын усны нөөцийн менежмент” сэдэвт анхдугаар хурлыг зохион байгуулав.

“Ай Ти Би Берлин-2012” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох байгууллагуудыг баталгаажуулан, үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг хангах талаар холбогдох хурлыг гүйцэтгэгч талтай хамтран зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж дууслаа.

### **Батлан хамгаалах салбарт**

Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын хуралдаанаар 2012 онд хугацаат цэргийн албанд татах, гэрээт цэргийн албанд элсүүлэх иргэдийн тоо, цэрэг халалт, таталтын хугацаа тогтоох тухай хэлэлцэж, Засгийн газрын мн/76 тоот тогтоолыг батлав.

ҮАБЗ-өөс өгсөн чиг үүргийн дагуу цэрэгжилт, үй олноор хөнөөх зэвсэг, гамшгаас хамгаалах хичээлийг ЕБС-ийн сургалтын агуулгад тусгуулахын тулд хичээлийн хөтөлбөрийг 3 хувилбартай боловсруулан хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Судан Улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хоёрдугаар шатны эмнэлгийн II ээлжийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлж, багийн хэрэгцээнд шаардлагатай байгаа чичрэг өвчний эсрэг хэрэглэх Мефлокүйн эмийг цэргийн багт хүргүүлээд байна.

ОБЕГ-аас өгсөн гамшгаас хамгаалах дадлагын дуут дохиогоор бие бүрэлдэхүүн "Монгол улсад учирч болзошгүй хямралын үед хүчний байгууллагуудын хамтарсан харилцан ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөө"-ний дагуу ажлын байраа түр орхин, аюулгүй орчинд гарах талаар дадлага хийлээ.

Афганистан Улсын "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн хамгаалалтын ротын VI, нисдэг тэрэгний засвар Пйлчилгээний багийн IV ээлжийн цэргийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг амжилттай зохион байгуулж, ажиллагааны газар оронд илгээв.

Хугацаат цэргийн алба хаагчдад хос мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан гагнуурчин бэлтгэх дамжаанд нийт 50 хугацаат цэргийн алба хаагч хамруулж, гагнуурчин мэргэжил эзэмшүүлэн анги, салбарт нь илгээлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР